

Монгол хэлний *Bel-* язгуурын утга учир...<sup>▼</sup>

Ц. Шагдарсүрэн (МУИС)

Энэхүү өгүүлэлийг бичигч "Монгол хэлний *"qoyar / jirin"* гэдэг тооны нэрийг мөшгисөн нь"<sup>1</sup> хэмээх өгүүлэл бичиж Солонгосын Алтай судлал нийгэмлэг (The Altaic Society of Korea)-ийн хуралд 1998 онд илтгэл тавьж хэлэлцүүлсэн бөгөөд түүндээ монгол хэлний *belbesün* гэдэг үгийн талаар товч төдийхөн хөндөөд энэ тухай дараа тусхай өгүүлэл бичихээр амласан билээ.

Энэ завсар "Эрдэнийн товч" хэмээх түүхэн сурвалжид бидний судлагдахуун болж буй *belbesün* гэдэг үгтэй нэгэн язгуур бүхий *belgürde-* (*belgürte-*?) гэдэг нэгэн сонирхолтой үг байгаа нь түрүүчийн судлагаанд тэмдэглэсэн саналыг минь улам ч лавшруулан өглөө. Уг үг зөвхөн "Эрдэнийн товч" ийн бараг бүх хувилбаруудад тохиолдох бөгөөд тухайн өгүүлэмж бүхий "Алтан товч"<sup>2</sup>, "Шар тууж"<sup>3</sup> болон "Чингис хааны Алтан товч нэртийн цадиг"<sup>4</sup> зэрэг бусад сурвалжид уг үгийг өөрчилөн найруулсан буюу орхисон байх тул *belgürde-* (*belgürte-*?) гэдэг үг XVII зууны үед ч утга санаа нь төдий л тодорхой бус болчихсон байсаныг гэрчилэж байгаа хэрэг. Үүний дээр "Ордос толь"-д<sup>5</sup> энэхүү *belgürde-* (*belgürte-*?) гэдэг толгой үгэнд франц орчуулгыг шууд хадалгүйгээр, холбогдох жишээ өгүүлбэрийг (утгачилан) орчуулсан байх ба "Эрдэнийн товч"-ийн нэг хувилбарт<sup>6</sup> эхний удаа хэвээр нь, нөгөө тохиолдолд өөр үгээр солисон нь үүний бас нэг баримт гэлтэй.

Олон эрдэмтэний гарын дор авсаар олдох эх буюу нэрт монголч эрдэмтэн И. Дө Рахевильз (Igor de Rachewiltz) нарын нийтлүүлсэн "Эрдэнийн товч"-ид буй холбогдох хоёр өгүүлэмжийг эшлэн авч үзэе.

<sup>▼</sup> 2004 оны 8-р сарын 10-11-нд Улаанбаатар хотноо болсон "Бельги, Холланд дахи Монгол судлал: А. Мостертийн судлагааны өв уламжлал" (The International Symposium "Mongol Studies in Low Countries: Antoine Mostaert's Heritage") нэрт олон улсын хуралд таьж хэлэлцүүлсэн илтгэл.

<sup>1</sup> Ц. Шагдарсүрэн, Монгол хэлний *"qoyar | jirin"* гэдэг тооны нэрийг мөшгисөн нь - *Altaic Hakpo* (Journal of the Altaic Society of Korea), No. 9, June 1999, Seoul, (pp. 313-334) 327-р тал / - *Acta Mongolica* [Centre for Mongol Studies, Nat. Univer. of Mongolia], Tom. 3 (216), Ulaanbaatar, 2003, (33-52) 44-р тал.

<sup>2</sup> *Altan tobč*, Ulaanbaatur, 1990; Hans-Peter Vietze, Gendeng Lubsang, *Altan tobč*, Tokyo, 1992.

<sup>3</sup> (Н. П. Шастина,) *Шара туджи - Монгольская летопись XVII века*, Москва-Ленинград, 1957.

<sup>4</sup> *Činggis qaγan-u Altan tobč ner-e-tü-yin čadiγ* - Činggis qaγan-u takil-un sudur orosiba, Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriγ-a, 1998, 60-61, 107.

<sup>5</sup> Antoine Mostaert, *Dictionnaire Ordos*, I-III vol. - Monumenta Serica, Monograph Series V, Peking, 1941, 1942, 1944, 64.a-b,

<sup>6</sup> *Erdeni-yin tobč*, - Monumenta Historica, Tom. I, Fasc. I, Keblel-dü beledkegsen Се. Nasunbaljur, Ulaanbaatur, 1961, 128 (A text); *Qad-un ündüsün Erdeni-yin tobč*-a, "Eine Pekingер Palasthandschrift"- Herausgegeben von Erich Haenisch, - Asiatische Forschungen, Band 14, Wiesbaden, 1966, ss. 179, 212.

### 1-р өгүүлэмж:

37. v. 10. ...Börte jüsin  
37. v. 11. Sečen sutai tayiqu iserin dotur-a ögüler-ün:  
37. v. 12. **Belgürten** yabuqui čay-tur činu: Belen-e učaraju sayitur  
37. v. 13. nöküčen: Berke üiles-i činu bütügejü öggün: Bey-e  
37. v. 14. amiban ese qayiralaysan Boyurči bisi bileü: ...<sup>7</sup>

### 2-р өгүүлэмж:

41. r. 10. ...Sönid-ün Gilügen bayatur eyin  
41. r. 11. öcir-ün: Qayiratu Börte jüsen sečen qatun činu üküm j-e:  
41. r. 12. Qas erdeni metü törü činu samayuram j-e: Qasar Belgütei  
41. r. 13. qoyar-činu **bülegedem j-e**: Qaralmai yeke ulus činu qay-a  
41. r. 14. kereg tarqam j-e: Üčüken-eče učiraysan Börte jüsin sečen  
41. r. 15. qatun-činu üküm j-e: Öndür boluγsan törö jasaγ činu  
41. r. 16. boyunidum j-e: Ögedei Tolui qoyar (köbegün) činü öničidem j-e:  
41. r. 17. Ürisün (öriksen<sup>Ts. Sh.</sup>) jögegsen albatu ulus činu ejegüyidem j-e:  
41. r. 18. Onoju dokiγsan Börte jüsin sečen qatun-činu üküm [j]-e:  
41. r. 19. Očigin Qaçigin qoyar degüü-čünü **belgürtem j-e**: olan-a  
41. r. 20. jögegsen qayiran yeke ulus-činu tarqam j-a: ...<sup>8</sup>

Дээрхи хоёр өгүүлэмжид онцлон тэмдэглэсэн **belgürtem-j-e**, **bülegedem-j-e** [Mo. bölügdem-j-e<sup>Ts. Sh.</sup>] хоёр үг утгын хувьд сонирхолтойн дээр сурвалжийн бусад эхүүдэд өөр үгээр солисон тохиолдолд дээрхи хоёр үгийг нэгэн үгээр орлуулсан зэрэг судлагчдын анхааралыг багагүй татаж байгаа учир эл хоёр үгийн гарал, уугуул утга санааг монгол хэл шинжлэл болон учир шалтгааны үүднээс тэнхрүүлэх зорилгыг тавив. Иймэд шууд холбогдох бусад хувилбарууд болон орчуулгад ямар байгаа, хэрхэн орчуулсан зэрэгийг харьцуулан үзэе.

#### 1. **belgürde-** (**belgürte-** ?) гэдэг үгийн тухайд...

1. **belgürde-** (**belgürte-** ?) гэдэг энэ үг “Эрдэнийн товч”-ийн бусад хэд хэдэн эхэд ямар байгааг авч үзсүгэй.

1. 1. 1961 онд Улсын Нийтийн номын сангийн хөмрөгт хадгалагдаж байсан дөрвөн эхийг харьцуулан нийтлэсэн ахмад түүхч Ц. Насанбалжир “Эрдэнийн товч”-ийн сонгомол эх (цаашид Ц. Н. [Ts. Na.] хувилбар хэмээнэ)-эд бидний судлахуун болгож буй **belgürde-** гэдэг үг мөн хоёр удаа энэ **belgürde-** гэдэг хэлбэрээр тохиолдож байна. Харин “А” хувилбарт уг үгийг эхний тохиолдолд хэвээр нь, хоёдугаар тохиолдолд **yutuγu qočur-** гэдэг үгээр солисон байна хэмээн тэмдэглэжээ<sup>9</sup>.

Үүнээс үзэхүл Ц. Насанбалжир авгайн ашигласан “А” хувилбар нь Эрх Хейниш профессорын хэвлүүлсэн барын эхтэй яг тохирч байна<sup>10</sup>. Дээр эшлэн авсан хоёр өгүүлэмжийн

<sup>7</sup> Igor de Rachewiltz, John R. Krueger, Ulaan, *Erdeni-yin tobčā (Precious summary) - A Mongolian Chronicle of 1662, Urga Text, I, Canberra, 1990, p. 73.*

<sup>8</sup> Igor de Rachewiltz, John R. Krueger, Ulaan, *Erdeni-yin tobčā (Precious summary) - A Mongolian Chronicle of 1662, Urga Text, I, Canberra, 1990, p. 80.*

<sup>9</sup> *Erdeni-yin tobčā*, - Monumenta Historica, Tom. I, Fasc. I, Keblel-dü beledkegsen Če. Nasunbaljur, Ulayanbayatur, 1961, 115, 128-р тал.

<sup>10</sup> *Qad-un ündüsün Erdeni-yin tobčā-a*, “Eine Pekingener Palasthandschrift”- Herausgegeben von Erich Haenisch, - Asiatische Forschungen, Band 14, Wiesbaden, 1966.

эхиний (буюу 37. v. 12.-т буй) **belgürde-** гэдэг үг хэвээрээ байгаа боловч хоёрдахи удаа (буюу 41. r. 19.)-д **yutuju qoǰur-** гэдэг үгээр сольжээ<sup>11</sup>.

1. 2. 1996 онд Э. Хиодо (Elisabetta Choido) К. Загастер (Klaus Sagaster) нарын гэрэл зурагаар хэвлүүлсэн “Эрдэнийн товч”-ийн “Хэнтийн хувилбар” [Kentei]-т мөн л **belgürde-** гэдэг хэлбэрээр тохиолдож байна<sup>12</sup>.

1. 3. Чухам хаанаас олдсон нь тодорхойгүй “Хаадын үндүсүн Эрдэнийн товчи хэмээх түүх орошибай” гэдэг өөр нэг хувилбар (цаашид Ц. Ш. [Ts. Sh.] хувилбар хэмээнэ) энэхүү өгүүлэлийг бичигчийн цуглуулгад буй бөгөөд түүнээс үзэхүл, эхиний тохиолдолд **belgürde-** гэж, хоёрдугаар тохиолдолд **bilgürde-** гэж *i* эгшигтэй буюу хоёр янзаар уг үгийг тэмдэглэжээ<sup>13</sup>. Өөрөөр хэлбэл үндсэндээ адил байна гэсэн үг.

1. 4. Ц. Насанбалжир авгайн “Эрдэнийн товч”-ийн судлагаанаас үзвэл түүний “А” хэмээх хувилбар буюу Э. Хэйнишийн хэвлүүлсэн модон барын эх (цаашид Е. Haenisch [E.H.] хувилбар хэмээнэ)-эд уг үгийг түрүүн удаа хэвээр нь, дараагийн удаад **yutuju qoǰur-** гэдэг үгээр солисон гэдэгийг дээр өгүүлсэн билээ<sup>14</sup>. Ийнхүү солисон байдалыг үзвэл тухайн хам сэдэвийн утгыг харгалзасанаас биш хэлшинжлэлийн талаас уг үгийн гарал болон уугуул утга, тухайн үеийнхи утга санааг төдий л анхаараагүй гэж үзэх үндэс бүрэнээ харагдана.

1. 5. 1998 онд Доорунгаагийн нийтлүүлсэн “Чингис хааны тахилын судар оршив” номд орсон *Činggis qaγan-u Altan tobā ner-e-tü-yin čadiγ* (цаашид *Doo* гэж товчилоно) хэмээх зохиолд Гилүгэн баатарын өчил шүлэгийн нэгэн товч хувилбар буй бөгөөд Очигу, Хачигу хоёрын тухайд “Эрдэнийн товч” дахи **belgürde-** хэмээх үгийг энд **bölegede-** гэдэг үгээр солижээ<sup>15</sup> (энэ талаар хоёрдугаар хэсэгт дэлгэрүүлэн өгүүлнэ).

2. Тэгвэл энэхүү гэдэг **belgürde-** / **bilgürde-** гэдэг үг хэрхэн үүссэн, утга ямар утгатай байсан бэ? гэдэг асуулт аяндаа гарч ирэх нь мэдээж билээ.

Энэхүү үг Антуан Мостаер (Antoine Mostaert) авгайн 1941 оны “Ордос толь”-д тохиолдох бөгөөд франц тайлбары нь үзвэл **belgürte-** = **belgürt'e-** гэдэг толгой үгэндээ шууд орчуулга хийлгүй, *Би хүнгүй бэлгүрдэж байна, хийдэлдээ бэлгүрдэ-, албанд бэлгүрдэ-* гэх зэрэг уг уг орсон өгүүлбэрийн орчуулгыг хадсан нь тухайн үг тэр цагтаа бие даасан ямар утгатай байсан нь нарийн тодорхойгүй тул өгүүлбэрийн хам утгаас нь үүдүүдэн орчуулжээ гэж үзэх үндэс буйг харуулж байна. Үүнд:

**Bi k'ün üg'ṭ belgürt'edži wān** *Je suis très occupé parce qu'il n'y a personne qui m'aide*  
(Надад туслах хүн үгүй учир би тун зав чөлөөгүй байна)

**K'idelt'ëë belgert'e-** *être très occupé de son travail* (ажилдаа түүртээд завгүй бай-)

**Albandu belgert'e-** *parvenir difficilement à payer les impôts parce que qu'ils sont trop lourds*  
(алба гувчури хүндийн учир төлөхөд бэрхэдэ-)<sup>16</sup>

<sup>11</sup> *Qad-un ündüsün Erdeni-yin tobāy-a*, “Eine Pekinger Palasthandschrift”- Herausgegeben von Erich Haenisch, - Asiatische Forschungen, Band 14, Wiesbaden, 1966, ss. 179, 212.

<sup>12</sup> *Sayang Sečen ERDENI-YIN TOBČI*, A manuscript from Kentei Ayimag, Edited and Commented on by Elisabetta Choido with a Study of the Tibetan Glosses by Klaus Sagaster, Asiatische Forschungen, Band 132, Wiesbaden, 1996, 93 p + Facsimile, 46. r. 7, 52. v. 25.

<sup>13</sup> *Qad-un ündüsün erdeni-yin tobā kemekü teüke orosiba* (Ts. Shagdarsureng Version), 25. r. 03, 27. v. 04.

<sup>14</sup> *Erdeni-yin tobā*, - Monumenta Historica, Tom. I, Fasc. I, Keblel-dü beledkegsen Če. Nasunbaljur, Ulayanbayatur, 1961, 128-p тал.

<sup>15</sup> Дорун-а, *Činggis qaγan-u takil-un sudur orosiba*, Kökeqota, 1998, 61, 107-p тал.

<sup>16</sup> Antoine Mostaert, *Dictionnaire Ordos*, I-III vol. - Monumenta Serica, Monograph Series V, Peking, 1941, 1942, 1944: 64.a-64.b.

гэж орчуулсан нь уг үгийг яс оноож бус, тайлбар маягаар франц болгосоныг харуулж байшаа хэрэг юм. Мөн А. Мостаер авгай энэ үгийн авиа сэлгэсэн хувилбар нь *belbert'e*- гэж байдагийг нэмэн заагаад *үүртэ-* (*түүртэ-*) гэдэг үгтэй утга адил гэж тэмдэглэжээ<sup>17</sup>.

Ц. Насанбалжир авгайн “*Эрдэнийн товч*”-ийн судлагаанаас үзвэл түүний “А” хэмээх хувилбар буюу Э. Хэйнишийн хэвлүүлсэн эхэд уг үгийг түрүүн удаа хэвээр нь, дараагийн удаад *jutuju qoǰuru-* гэдэг үгээр солисон гэдэгийг дээр өгүүлсэн билээ<sup>18</sup>. Ийнхүү солисон байдалыг үзвэл тухайн хам сэдэвийн утгыг харгалзасанаас биш хэлшинжлэлийн талаас уг үгийн гарал болон уугуул утга, тухайн үеийнхи утга санааг төдий л анхаараагүй ажээ гэж үзэх үндэс бүрэнээ харагдана.

Энэ бүхэнээс үзэхэд *belgürde-* гэдэг үгийн хэрэглээ саарч бичигээр л дамжин ирсэн тул “*Эрдэнийн товч*”-ийг зохиох тэр цагт уугуул утга санаа нь хэдийнээ бүдэгшин мартагдах тийшээ хандсан байжээ.

2. 1. Тэгвэл энэхүү *belgürde-* гэдэг үг анх хэрхэн үүссэн хийгээд угтаа ямар утга илэрхийлж байсан бэ? гэдэг асуулт эрхгүй хариу шаардах тул мөшгин үзсгэй.

Профессор И де Рахевильз “*Эрдэнийн товч*”-ийн судлагааныхаа сүүлд оруулсан “*Эргэлзээтэй үгс*” (*Problem words*) гэдэг хэсэгтээ эл *belgürde-* гэдэг үгийг багтааж англиар *To be very bussy or fully occupied; to find it difficult (to do something)* хэмээн мөн л тайлбар маягаар орчуулсан<sup>19</sup> байх ба яргуулан хөөж үзвэл уг утга санааг А. Мостаер авгайн “*Ордос толь*”-ийн франц тайлбар орчуулгаас авсан болох нь тодорхой харагдаж байна.

Энэхүү *belgürde-* гэдэг үгийн гарал үүсэл болоод уугуул утгыг тодруулахад тухайн эх бичвэр дэхи хам утга санаа, мөн монгол төдийгүй Алтай овог хэлний үг бүтэх ёсон, утгазүйн судлагааг эрхгүй анхаарах шаардалгатай болно гэж үзэж байна.

Ингэж үзвэл “*Эрдэнийн товч*”-ид хоёр удаа тохиолдож буй эл *belgürde-* гэдэг үгийн эхнийнхи нь буюу нэгдүгээр өгүүлэмжид: хүн хүчгүйн учир алдсан найман шарга морио нэхээр Тэмүжин *ганцаар явж байгаа* үетэй холбоотой ажээ. Хоёрдахи тохиолдолд буюу 2-р өгүүлэмжид: чилээрхэн буй Чингис хаантаныг тэнгэр халиж үгүй болох бөгөөс үлдэж хоцорсон хатад, үр хөвгүүд чинь *бэлбэсэрэх болно, өнчирөх болно, ганцаардах болно* гэсэн нэгэн гол санаа Сөнидийн Гилүгэн баатарын өгүүлэж буй яруу тансаг шүлэгт нэвт шувт хаван гарсан байна. Утгазүйн үүднээс, эдгээр баримт нь бидний судлагдахуун болж буй *belgürde-* гэдэг үгийн гарал болон уугуул утгыг сэргээн тэнхрүүлэхэд онцгой чухал үүрэг гүйцэдхэнэ гэж үзэж байна. Тэгвэл энэ үг чухам ямар язгуураас хэрхин үүсч, ямар утга агуулж байсан бэ?

Дээрхи хам бичвэрийн утгаас үзвэл ерөнхийдөө “*ганцаардах*”, “*ганцаар болох*”, “*ганцаар байх*” гэсэн утга илрэх бөгөөд шүлэгийн доторхи хоёр тохиолдолын

**Belgürden** yabuqui čag-tur činu:  
Belen-e učaraju sayitur nöküčen: ...

гэсэн мөрийн **Belgürden** yabuqui гэдэг нь “*ганцаардан явах*” гэсэн утга, нөгийхи хоёрдахи тохиолдолын

Očigin Qačigin qoyar degüü-čünü **belgürdem j-e:**

<sup>17</sup> Antoine Mostaert, *Dictionnaire Ordos*, I-III vol. - Monumenta Serica, Monograph Series V, Peking, 1941, 1942, 1944: 63..b.

<sup>18</sup> *Erdeni-yin tobčā*, - Monumenta Historica, Tom. I, Fasc. I, Keblel-dü beledkegsen Če. Nasunbaljur, Ulaγanbayatur, 1961, 128-р тал.

<sup>19</sup> Igor de Rachewiltz, John R. Krueger, Ulaan, *Erdeni-yin tobčā (Precious summary) - A Mongolian Chronicle of 1662, Urga Text*, I, Canberra, 1990, pp. 207-208.

гэсэн мөрийн *belgürdem j-e* гэдэг нь хоюулаа “ганцаардам-за” гэсэн утгатай нь тодорхой харагдана. Утгын хувьд ийм бөгөөс уг үг хэрхин үүссэн бэ? асуулт аяндаа гарах болно. Бид энэхүү *belgürde-* гэдэг үгийг гарлын хувьд *belbesün* (бэлбэсэн ~ бэлэвсэн), *belär* (бэлчир) гэдэг үгтэй хэлбэрсудлал болон утгазүйн үүднээс нэгэн язгууртай хэмээн үзэх бүрэн үндэстэй юм. Эл хоёр үгийн тайлбарыг толь бичигээс сөхөн үзэвэл:

**БЭЛБЭСЭН I** хань нөхөрөө үхүүлсэн, эргүй эм ...  
**БЭЛБЭСЭН II** малын дан ганц зүс  
**БЭЛЧИР** уулзар, уулзвар, нийлбэр; олон замын бэлчир, голын бэлчир.  
**БЭЛЧИРЛЭХ** уулзварлах, бэлчир нийлэх.

хэмээн тайлбарлажээ<sup>20</sup>. Үүнээс үзэхэд утгаа хоёр буюу түүнээс олон юм ганц болох, эсвэл нэгэн цэгт нэгдэн уулзах гэсэн утга тодорхой байна. *Бэлчир* гэхэд *чөдөрийн бэлчир, замын бэлчир, голын бэлчир* гэх зэрэгээр цөм салаалсан зүйлийн нэгдэн уулзасан уулзуурыг заадаг билээ.

Алтай язгуурын бусад хэлэнд ч эл язгуур мөн л энэ утгаараа буй. Тухайлбал: *бэлчир* гэдэг үг Уйгурт *белтур*; Түва хэлэнд *белдир*; *бэлбэсэн* гэдэг үг уйгурт *бееа* гэдэг хэлбэрээр дайралдаж байна<sup>21</sup>. Бас манж хэлнээ *нийт, нийтээр* гэсэн утга бүхий *bireme ~ biretei* гэдэг үг буй.

2. 2. Дээрхи баримт сэлтэд үндэслэн *belgürde-* гэдэг үг нь *belbesün* гэдэгтэй нэгэн язгууртай, утгаа “ганцаарда-, ганцаар бол-” гэсэн утгатай байсан бөгөөд цагийн саалтад зөвхөн бичигийн зохиолд хязгаарлагдмал хэрэглэгдэх болсоноор яваандаа утга санаа нь бүдгэрч А. Мостаерт авгайн толь бичигийн хэрэглэгдэхүүн цуглуулах үест хүн хүч дутмагийн учир (ажил төрөл, хийдэлдээ) түүртэх хэмээн ойлгогдоход хүрсэн байна гэж хэлэх үндэслэл гарч байна. “Ордос толь”-дахи дээр эшлэсэн жишээнд буй *belgürde-* гэдэг үгийг *ганцаарда-* гэдэг үгээр солисон ч уг утга онц өөрчлөгдөхгүй болох нь үүний бас нэгэн баримт юм. Тэгээд ч “Шар тууж”-ид буй *belgürde-* гэдэг үгийг *ганцаарда-* гэдэг үгээр солисон баримт буй бөгөөд хойно энэ талаар илүү дэлгэрүүлэн өгүүлнэ<sup>22</sup>.

Тэгвэл “Эрдэнийн товч”-ийн орчуулгуудад хэрхэн буулгасныг авч үзье. Манжийн хааны зарлигаар уг сурвалжийг манж, хятад хэлээр орчуулсан бөлгөө. Японд гэрэл зураг татаж хэвлэсэн манж орчуулгыг үзвэл гол үйл явдалд илүүтэй анхаарч сурвалжийн шигтгээ болгон завсараар нь оруулсан уран зохиол, домогийн хэсэгийг орхисон тул бидний судлагдахуун болж буй өгүүлэмж бүхлээрээ орхигджээ. Харин хятад орчуулгыг Улаан профессорын хэвлүүлсэн эхээс үзвэл *belgürde-* гэдэг үгийн хоёр тохиолдлыг “хүчирдэх, зовох, чадалгүй болох ...” гэдэг үгээр хятадчилсан нь мөн л тухайн өгүүлэмжийн хам утгад нь үндэслэсэн гэж үзэж болно.

*belgürde-* гэдэг үгийн тухайд нэмэн хэлэх нэгэн зүйл буй. “Ордос толь”-д энэ үгийг *belgürte-* гэж *-t-* гийгүүлэгчтэй тэмдэглэсэн нь тухайн нутагийн дуудалга, аялгуутай холбоотой буй заа. Үүнээс үүдэж “Эрдэнийн товч”-дахи уг үгийг профессор И. Де Рахевильз авгай мөн л тэр хэвээр нь *belgürte-* гэж галиглажээ. Самгарда-, үүлгэрдэ- гэх зэрэгээр үйл үгийн идэвхигүй үндэсээс дам үйл үг үүсгэдэг *-da- / -de-* дагавар буй. Монгол хэлний үг бүтэх ёсыг нарийнаа тусгаж чадсан монгол бичигийн зөв бичих зүйн ёсоор, хэрэвээ *-t-* гийгүүлэгчтэй байсан бөгөөс *-te-* бус, *-tü-* гэж бичих ёстой билээ. Үүнээс үүдүүлэн хэлэхэд бас нэр үндэсээс үйл үг үүсгэдэг *-da- / -de-, -tu- / -tü-* гэсэн хоёр өөр дагавар буй бөгөөд цөм утга ялгадаг боловч орчин цагт “шинэ” үсэгийн дүрэмээс болж үүний ялгааг олонхи хүн мэдэхгүйн харгайгаар *бохирдо-* (хэтэрхий бохирын учир хэрэглэх аргагүй), *бохирто-* (улам уламаар бохир болох) гэдэг хоёр өөр утга илэрхийлж байсан хэлбэр<sup>23</sup> их төлөв ганц хэлбэрээр, ганц утгаар хэрэглэгдэх болсон нь монгол хэлний утга ялгах сэтгэлгээний нэгэн чухал ялгаа мартагдан үгүй болж байгаа хэрэг.

<sup>20</sup> Я. Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 121.б, 122.а

<sup>21</sup> Sečen соүти, *Mongjol üges-ün ijajur-un toli*, Kökeqota, 1988, 705.б; *Русско-узбекский словарь*, Москва, 1954, стр. 56.б; *Тувинско-русский словарь*, Москва, 1968, стр. 98.а; *Русско-тувинский словарь*, Москва, 1980, стр. 378.а.

<sup>22</sup> (Н. П. Шастина.) *Шара туджи - Монгольская летопись XVII века*, Москва-Ленинград, 1957, стр. 28.

<sup>23</sup> Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, 95-р тал; Ш. Чоймаа, *Монгол, кирил бичгийн зөв бичих зүйн харьцуулсан судалгаа*, Улаанбаатар, 2003, 92-95-р тал.

3. Дээрхи баримт сэлтээс улбаалан, бидний судлагдахуун болж буй **belgürde-** (**belgürte** ?) гэдэг үгтэй нэг язгуур үндэс бүхий өөр ямар үг байж болох вэ? гэдэг талаар ярилцая. Цуваа цагийн үүднээс бүр эрт цагт буюу өвөг Алтай хэлний үед хүргэн мөшгиж тэнхрүүлбэл: *belbesün* (бэлбэсэн ~ бэлэвсэн), *belār* (бэлчир) гэх зэрэг үгтэй язгуур нэг **belgürde-** гэдэг үгийн уугуул гаралыг одоо цагийн олон түрэг хэлнээ буй “нэг” гэсэн утга бүхий **bir** гэдэг үгтэй холбож үзэх боломжтой бөгөөд монгол бичигийн хэлний *nigen*, *beläger* гэх зэрэг олон угийг эдүгээ нэг (< Mo. *nigen*), *билчээр* (< Mo. *belciger*) гэх зэрэгээр хэлдэг болсон буюу монгол хэлнээ *i ~ e*, *e ~ i* сэлгэдэг баримттай холбон үзэх үндэстэй. Дээр өгүүлсэн манж хэлний *нийт*, *нийтээр* гэсэн утга бүхий *bireme ~ biretei* гэдэг үгийн эхиний *-i-* эгшигийн асуудалыг ч үүнлүгээ холбон үзэж болно. Энэ ташрамаар тэмдэглэхэд, Алтай хэлний нийтлгийн аливаа асуудалыг авч ярихад, зарим хүмүүсийн үздэгчилэн хожим орсон үгийн жишигээр тайлбарлах үндэс байхгүйг онцлон тэмдэглэвэл зохилтой бөгөөд энэ тухай түрүүн нэг бус удаа тэмдэглэсэн зүйл бий<sup>24</sup>.

Орчин цагийн монгол хэлнээ гол төлөв 1-4 хүртэлхи энгийн тооны нэрийн дараа ордог – *мөсөн* (< Mo. *-musun / -müsün*) хэмээх дагавар байдаг бөгөөд энэ нь *тухайн дагуулсан тоо бүхий зүйл “нэгэн цогц болсон”* гэдэг утга илэрхийлдэг билээ. Үүнд:

(Mo. *nigemüsün*) *нэгмөсөн* ‘нэг дор, нэг амиар’; Жишээ нь: *Би ажилаа нэгмөсөн дуусгав.*

(Mo. *qoyimusun*) *хоймсон* ‘хоёр зүйлээс бүрдсэн нэг юм’; Жишээ нь: *хоймсон роман.*

(Mo. *jirmüsün*) *жирмэсэн* ‘бие давхар, хөл хүнд’; Жишээ нь: *жирмэсэн эхнэр.*

(Mo. *yurmusun*) *гурмасан* ‘гурван зүйлээс бүрдсэн нэг юм’; Жишээ нь: *гурмасан чөдөр* (гурван сур нэгтгэн эрчилэж хийсэн чөдөр).

(Mo. *dörmüsün*) *дөрмөсөн* ‘дөрвөн зүйлээс бүрдсэн нэг юм’; Жишээ нь: *дөрмөсөн хошлон* (дөрвөн дээс зэргэцүүлэн хийсэн буслүүр)...<sup>25</sup>

Үүнээс гадна Mo. *-müsün* гэдэг дагаварын өмнө ордог, монгол хэлний *нэгмөсөн* гэдэг утга бүхий **бүрмөсөн** [Mo. *Bür(i)müsün*], *гагцаар үлдсэн* гэсэн утга бүхий **бэлбэсэн** [Mo. *belbesün* < Mo. *\*belmesün* < Mo. *\*belmüsün*], *бие давхар, хөл хүнд* гэсэн утга бүхий **жирмэсэн** (Mo. *jirmüsün*) гэдэг нэрийн эхиний хэсэг нь ‘нэг’, ‘хоёр буюу *jir* (< Mo. *jirin*)’ гэсэн утга илэрхийлдэг *тооны нэр болох нь төвөггүй мэдэгдэнэ.*

4. Энэ бүхэнээс үзэхүл, **нэгмөсөн**, **бүрмөсөн**, **бэлбэсэн** зэрэг үгийн эхиний хэсэг нь цөм ‘нэг, ганц’ гэсэн утга илэрхийлэж байна. Тухайлбал: монгол хэлнээ **бэлбэсэн** гэдэг үг нь *нөхөр ханиа нөгчөөж ганцаар үлдсэн хүн* дээр хэлэхийн сац, малын зүс дээр алаг, цоохор бус, *дан нэгэн өнгийн зүсэм-ийг заадаг бөлгөө*<sup>26</sup>.

“*Шар тууж*”-д бидний эхлэн эшлэл болгож авсан нэгдүгээр өгүүлэмжтэй тохирох хэсэг буюу Боорчийн тухайд Өөлүн үжингийн шөне хэлж буй үгийг үзвэл:

... söni Börte sečen sutai {B., C. sudi} tayiqu ögüler-ün {B. ögüler-e):

Гауцагар yabuqui-tur[=dur<sup>Ts. Sh.</sup>]-čini

Qaγačal-ügei yabuju

Küčün-iyen öggügsen

Гауца Вүчүрчи биси билеү: ... (*Шар тууж*, 31)<sup>27</sup>

<sup>24</sup> Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), N. 6 (1998), Seoul, 1999, (pp. 61-139) 7-8-р тал; Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл бичиг, II дэвтэр), Улаанбаатар, 1999, (67 - 125) 71-72-р талаас үзмүү.

<sup>25</sup> Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний “цоуар | jirin” гэдэг тооны нэрийг мөшгисэн нь* - *Altai Hakpo* (Journal of the Altaic Society of Korea), No. 9, June 1999, Seoul, (pp. 313-334) 326-р тал / - *Acta Mongolica* [Centre for Mongol Studies, Nat. Univer. of Mongolia], Tom. 3 (216), Ulaanbaatar, 2003, (33-52) 43-44-р тал.

<sup>26</sup> Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, 212. 6 тал.

<sup>27</sup> (Н. П. Шастина,) *Шара туджи - Монгольская летопись XVII века*, Москва-Ленинград, 1957, стр. 28.

хэмээн, "Эрдэнийн товч"-ид байсан *belgürde-* хэмээх үгийн оронд *гагцаар* гэдэг үгийг хэрэглэж, *хагацалгүй* гэдэгтэй (монгол бичигийн үүднээс ижил хэлбэр болох цэггүй<sup>28</sup> *ᠭᠠᠭᠴᠠᠭ* –аар буюу академич Ринчен багшитаны тэмдэглэсэнчилэн нүдээр үзэх байдалаар) толгой холбосон нь бидний саналыг давхар батлан өгч байна.

Иймд бидний судлагдахуун болж буй *belgürde-* гэдэг үг нь *бэлбэсэн*, *бэлчир* гэх зэрэг үгтэй язгуур нэг, утгаа "*ганцаарда-*" гэдэг утгатай байжээ гэж үзэх бүрэн үндэс харагдаж байна.

## 2. *bülegede-* / *bülügde-* (< Mo. *bölügde-*<sup>Ts. Sh.</sup>) гэдэг үгийн тухайд...

2. 1. Энэ өгүүлэлийн эхинд эшлэл болгож авсан хоёрдахи өгүүлэмжид Хасар, Бэлгүдэй хоёрын тухайд *bülegede-*<sup>29</sup> гэсэн үг буй бөгөөд үүнийг "Эрдэнийн товч"-ийн бусад эх болон холбогдох зохиолуудад *bülegede-* (Ts.Na. 128), *bülegde-* (Ts. Na. [E]: 128), *bülügde-* (Ts. Sh: 27. r. 34), *bülügde-* (Хэнтийн хувилбар, 52. v) гэх зэрэгээр зөрөөтэй бичсэн, түүнчилэн заримдаа утгы нь тодлож өөр үгээр солисон байдаг. Үүнд: Хэнтийн хувилбар (IV. 11. r.) болон Ts. Na. [A] (128-р тал) хувилбарт эл үгийг *yutuju qoǰur-* гэдэг үгээр солисон нь мөн л дээр өгүүлсэнчилэн *belgürde-* гэдэг үгийг зарим эхүүдэд ийнхүү сольсонтой яг адилхан тул тэр үед *belgürde-* / *bölügde-* гэдэг хоёр үгийн утгыг адил хэмээн үзэж байсаныг харуулж байна. Энэ үгийг "Ордос толь"-д нөгөөхи *belgürde-* гэдэг үгийн адилаар, бие даасан толгой үгийг нь орчуулалгүй, уг үг орсон жишээ өгүүлбэрийн хам утгад нь шүтэж, *belgürde-* гэдэгтэй утга ижил хэмээн нэг янзаар орчуулсан байдал харагдана<sup>30</sup>.

Мөн Доорунгаагийн нийтлүүлсэн "*Чингис хааны тахилын судар оршув*" [Doo] номд *Činggis qaγan-u Altan tobǰ ner-e-tü-yin čadiγ* хэмээх зохиол буй бөгөөд тэнд бидний эшлэн авч буй өгүүлэмжийн хоёрдугаар хэсэг буюу Гилгүн баатарын шүлэгийн нэг хувилбар арай товч байдалаар тохиолдох бөгөөд тэнд Хасар Бэлгүдэй хоёрын тухайд мөнөөхи *bülegede-* гэдэг үг хэвээрээ тохиолдох боловч нийтлүүлэгч уг үгийг зүүлтээр "*хүчирдэ-, чадалгүй бол-*" гэсэн утгатай хэмээн тодлосон байна<sup>31</sup>. Харин Очигу Хачигу хоёрын тухайд *belgürde-* гэдэг үгийг *bülegede-* гэдэг үгээр солисон байдаг тухай дээр товч дурдсан билээ. Үүнээс гадна Доорунгаа авгай уг сударыг монгол бичигээр эдүүгээчилэн буулгахдаа цөөнгүй үг хэлэлгэ, үгийн хэлзүйн хэлбэр, хүний нэр ус тэргүүтэнийг уг эхээс нь зөрөөтэй болгосон байдал багагүй буйг тэмдэглэх хэрэгтэй буй заа. Жишээлбэл: *bülegedem-j-e* гэсэнийг *bülegideku bolai;* , *Оǰу, Qaǰу* гэсэнийг *Ojuγu, Qaǰуγa* гэх зэрэгээр буулгажээ<sup>32</sup>.

Харин "*Шар тууж*" [Si. Tu.]-ид Хасар Бэлгүдэй хоёрын тухайд *bülügde-* гэдэг үгийг *yutuju qoǰur-* гэсэн үгээр сольж

Qasar Belgedei qoyar degüü činü yutuju qoǰuramja:  
Qamur-un jögegsen ulus činu taraqamja ...

<sup>28</sup> Монгол бичигийн уламжилалд *ла-, ле- ... ; ја-, јо- ...* тэргүүтэнд цэг тавих ёсон, түүнчилэн *ј-* / *у-* гийгүүлэгчийг ижил тэмдэглэж байсан шилбийг ялгах зорилгоор *у-* гийгүүлэгчийн хувьд үзүүрий нь дээш огшоох зэрэгээр ялгах болсон нь харьцангуй сүүл үед өргөн дэлгэрсэн бөлгөө. Утгаа тийнхүү ялгалгүй тэмдэглэж байсан нь (*халзан – галзан, засах – йасах* гэх зэрэгээр) нутаг нутагт сэлгэдэг байдалыг нийтлэг бодолцсон хэрэг байсан боловч сүүл үе-рүүгээ ялгаж болсон нь зонхилох аялгуутаны нөлөөгөө тусгах эрмэлзэл болон бусад аялгуутаны хувьд бие даах гэсэн гэнэн сонирхол хоёр сүлэлдэн зохицсонтой холбоотой буй-заа.

<sup>29</sup> Эл үгийг утгаа Mo. *bölügde-* гэдэг хэлбэртэй байсан гэж үзэх баримт нутлагаа хэдий сайтай боловч бидний эшлэж авсан номд нэгэнт *bülegede-* гэж байгаа тул тэр хэвээр нь авсан болно. Авианы хувиралын зам чийрийн тухайд хойно тодруулан өгүүлнэ.

<sup>30</sup> Antoine Mostaert, *Dictionnaire Ordos*, I-III vol. - Monumenta Serica, Monograph Series V, Peking, 1941, 1942, 1944: 102. b.

<sup>31</sup> Dorunγ-a, *Činggis qaγan-u takil-un sudur orosiba*, Kökeqota, 1998, 60, 107-р тал.

<sup>32</sup> Dorunγ-a, *Činggis qaγan-u takil-un sudur orosiba*, Kökeqota, 1998, 60-61, 107-р тал.

хэмээн найруулжээ<sup>33</sup>.

Энэ үг 1985 онд Өвөр Монголд гарсан "Хураангуй Алтан товч" [QuATo]-ийн хятад орчуулгын хоёдугаар хавсралтад оруулсан монгол (хуулбар) бичвэр болон Ш. Чоймаа докторын 2002 онд эхбичигийн судлагаа хийж гаргасан "Хураангуй Алтан товч"-ийн аль алинд нь **bölügedü-** гэдэг хэлбэрээр тохиолдож байна<sup>34</sup>.

Энэ бүхэнээс үзэхэд XVII зуунд дуу дуугаа аван гарсан Монголын түүхийг туурвих үед эх хэрэглэгдэхүүн болгон ашигласан хуучин сурвалжид байсан **belgürde-** / **bölügde-** гэдэг хоёр үгийн уугуул утга санаа харьцангуй бүдгэрсэнээр зарим зохиогч уламжлалыг даган хэвээр хэрэглэж, зарим түүхч хам утгад нь шүтэж тэр цагтаа илүү ойлгомжтой гэсэн тайлбар маягийн үгээр солиж ирсэн нь тодорхой харагдана.

2. 2. Тэгвэл **bülegede-** / **bölügde-** (? < Мо: **bölügde-**) гэдэг үг хэрхэн үүссэн, утгаа ямар утгатай байсан хийгээд **belgürde-** гэдэг үгтэй ижил утгатай байсан уу? гэх зэрэг бие биесээ нөхөн тодруулах асуулт аяндаа гарч ирнэ. Энэ асуултыг бид үгийн гаралзүй, утгазүй огтлолцол болон учир шалтгааны холбоон дээр авч үзэхийг чармайсан болно.

"Эрдэнийн товч"-ийн хувилбаруудад дээр дурадсанчилан хэдэн янзаар бичсэн энэ үгийг монгол хэлний үг бүтэх ёсны үүднээс авч үзвэл утгаа **бөөн** (Мо. bögen ~ bögen), **бөөгнө-** (Мо. bögemne-), **бөөм** (Мо. bögem) болон **бөл цөл** ~ **бөлөг цөлөг** гэдэгийн **бөл** (Мо. bölü) гэх зэрэг олон үгтэй язгуур нэг, одоо оросжин шинэ үсэгээр **бүлэг** гэж тэмдэглэдэг боловч, утгаа **бөлөг** (Мо. bölüg) гэдэг нэрээс үүссэн үйл үгийн хэлбэр гэж үзэх үндэстэй байна. Эл язгуур зөвхөн монголд төдийгүй Алтай овогийн түрэг, солонгос хэлнээ мөн ийм утгаараа буй.

Тэр цагийн үйл явдалыг авч үзвэл их бага аль нэгэн зерчилийн уламаас Хасарын тухайд бусад хүмүүсээс арай өөрөөр буюу **bölügde-** гэдэг энэ үгийг хэрэглэх болсон түүхэн учир шалтгаан буйг бас үгүйсгэх аргагүй. Бидний хэрэглэгдэхүүн болгож буй хоёрдугаар өгүүлэмжид цөмд нь нэр заасан үйлийн эзэдийн ард нь Чингис хаантанд хамааруулсан "...-чинь..." гэдэг дагавар байхад зөвхөн Хэнтийн хувилбарт (52. v. 14) Хасар Бэлгүдэй хоёрын тухайд тэрхүү ойртуулан хамаатуулах "...-чинь..." байхгүй байгааг санамсаргүй орхисон алдаа гэж батлах баримт бас байхгүй.

Ийнхүү хэлний тогтолцоот чанарт шүтэн монгол хэлний үг бүтэх ёс хийгээд утгазүйн огтлол дээр авч үзвэл энэхүү **bölügde-** гэдэг үг нь "тусхай бөлөг болох" гэсэн харьцангуй сөрөгдүү утга илэрхийлж байсан гэж үзэх үндэстэйн дээр цагийн саалтаар нөгөөхи **belgürde-** гэдэг үгийнхээ хамт хоюулаа утга нь тодорхойгүй болж ирэхэд яруу найраг, шүлэгийн зохиолд утга санаа ойр, адил төстэй үг давтан ордог зарчим жишигээр "утга адил" үг гэж үзэхэд хүрч уламаар тухайн хоёр үгийг ойлгомжтой үгээр солихдоо ч мөн л тэр "зарчимаа" бодолцож **yutuju qočura-** гэдэг нэгэн адил үгээр солисон байх бүрэн боломж буй.

Үзэх хүнд дөхөмийг бодож судлагдахуун болсон хоёр үгээ холбогдох эхбичигүүдэд ямар ямар байгаа болон ямар үгээр хэрхэн солисон зэрэгийг нэг дор хүснэгтлэн үзүүлэе:

#### **Belgürde- (I)**

(Ts.Sh.: ...belgürden yabuqui čay-tur-āni...)

Igor de R.: belgürte- (37. v. 10)  
Ts. Sh.: belgürde- (25. r. 3)  
E. H.: belgürde- (III. 38. r. 5)  
Kentei: belgürde- (46. r. 7)

#### **Belgürde- (II)**

(Ts. Sh.:... Oāgin Qaāgin qoyar degüü-āni belgürdem-j-ē...)

belgürte- (41. r. 19)  
bilgürde- (27. v. 4)  
yutuju qočuru- (IV. 11. v. 3)  
belgürde- (52. v. 26)

<sup>33</sup> (Н. П. Шастина) *Шар тууж* Монгольская летопись XVII в., Москва-Ленинград, 1957, [орчуулга: 43-52] стр 36.

<sup>34</sup> *Hanyi Mengguhuangjin Shigang*, Kökeqota, 1985, 158; Ш. Чоймаа, *Qad-un ündüsün quriyangyui altan tobč*, - Monumenta Mongolica: Tomus II (Centre for Mongol Studies, NUM), Ulaanbaatar, 2002, 297-p тал, 32. а. 1.



Ts.Na.: [1]	belgürde- (p. 115)	belgürde- (p. 128)
[A]	belgürde- (p. 115)	γutuju qoçuru- (p. 128)
[E]	belgürde- (p. 115)	belgürde- (p. 128)
[I]	belgürde- (p. 115)	belgürde- (p. 128)

### Bölügde-

(Ts. Sh.: *Qasar Belgüdei qoyar-āni* [!?] *bölügdem-j-e...*)

Igor de R.:	bülegede- (41. r. 13)
Ts. Sh.:	bölügde- (27. r. 34)
E. H.:	γutuju qoçuru- (lv. 11. r. 4)
Kentei:	bölügede- (52. v. 14)
Ts.Na.: [1]	bölügede- (p. 128)
[A]	γutuju qoçur- (p. 128)
[E]	bölügde- (p. 128)
[I]	bölügede- (p. 128)
Doo:	bölügede- (60. b. 11)
SiTu:	γutuju qoçur- (стр. 36)
QuATo ('85):	bölügedü- (158)
QuATo ('02):	bölügedü- ('32.a.1)

Үүнчилэн хэлний тогтолцоот чанарыг ашиглан *үгийн гарал-утгазүй*-н огтлол дээр авч үзэх нь өдгөө тодорхойгүй болсон энэ мэт өдий төдий үгийн утга санааг тэнхрүүлэхэд үлэмжхэн ач холбогдолтой. Наад захын хэн бүхэний мэдэх баримт гэхэд "Монголын нууц товчоон"-ы 4-р зүйлийн сүүл хэсэгт буй *ne'ürit* гэдэг үгийн гарал-утгыг энэ маягаар мөшгин үзсэнээр,

Mo. *bayi + ri > bayiri* 'байр(и)'  
 Mo. *baγu + ri > baγuri* 'буу-рь',  
 Mo. *saγu + ri > saγuri* 'суурь',  
 Mo. *tuγu + ri > tuγuri* 'туурь' (1. 'үгийн бичиг', 2. 'барилга хийдийн орон суурь')  
 Mo. *jöge + ri > jögeri* 'зөөр' (буюу хурааж нөөсөн юм)

гэдэг тогтолцоогоор тэрхүү *ne'üri* гэдэг нь монгол бичигийн хэлний *negü*- "нүү-" гэдэг үйл үгээс

Mo. *negü + ri > negüri* 'нүүр(и)'

хэмээн үүссэн, монголчуудын нүүдэлийн (хол ойрын) зайг заасан үгийн дундад үеийн хөгжилийн хэлбэр болох нь тодорхой бөгөөд тийм ч учираас "Алтан товч"-ийн гар бичмэл эх (4. b)-ийн тохирох хэсэгт *negüri* гэдэг уг үгийн өмнө ном эрдэм нь буйлсан манай ахмад үеийнхин маань аль хэзээний *нүүдэл* хэмээх үгийг утга тодлон нэмэж бичсэн байдаг билээ. Дээрхи жишээнд авсан *зөөр(и)* гэдэг үгийн тухайд, одоогийн хүмүүс уг гарал хийгээд "зөөж хураасан юм" гэдэг утгы нь мэдэхгүй болсон учир зорилосон юм байх магадгүй гэсэн там тумхан мэдэлгээрээ *зоорь* болгож "засах"-ад хүрчээ. Уг үг энэ өгүүлэлийн гол судлагдахуун болж буй 2-р өгүүлэмжийн дотор ч мөн эл утгаараа буйгаас гадна ХҮII зууны бараг бүх монгол түүхэн сурвалжид уламжилаж ирсэн шүлэгийн дотор ...*өрсөн зөөсөн улс чинь өөр хүнийхи болом-за...*, ...*урьдын зөөсөн албат олон чинь цулгуйдам-за...*, ...*хамран зөөсөн улс чинь хамигаагаар тархам-за...* гэх зэрэгээр мөнөөхи уг утгаараа явж л байдаг. Мөн Чингис хаантай холбоотой халимаг аман зохиолд энэ үг уугуул утгаараа байсаар байгааг Б. Оконов тэмдэглэсэн байдаг бөгөөд англиар "*possessions*" гэж орчуулжээ<sup>35</sup>. Энэ мэт утга санаа нь одоо мартагдахад хүрсэн үг хэлэлгэ нэн олон, судлах эзэнээ хүлээж буй сэдэв бөгөөд ийм үгсийн гарал болон уугуул

<sup>35</sup> B. Okonov, *Brief Remarks on the image of Genghis Qan in Kalmyk folklore*, -The Chinggis Khan Szmposium in Memoriz of Gombojab Hangin, Ulaanbaatar, 2001, pp. 97-204, Cf. p. 201.

утгыг сэргээх шаардалга, ач холбогдол үлэмжхэн байна гэдэг санааг хөндөж үүнээс өмнө 1999 онд миний бие нэгэн илэдхэл тавьж дараа нь өгүүлэл болгож гаргасан билээ<sup>36</sup>.

**Асуулт хариулт, санал шүүмжлэл:**

**С. Жанчив:** "Монголын нууц товчоон"-д *bel* гэдэг үг хоёр удаа гардаг, яагаад түүнийг дурдсангүй вэ?

**Ц. Шагдарсүрэн:** "Монголын нууц товчоон"-д (5134, 9717-р мөр) *bel* гэдэг үг өгүүлбэрийн эхинд хоёр удаа гардаг. Би энэ удаа *bel* гэдэг үгийн тухай биш, *bel-* язгуурын тухай ярьж байгаа. Монголын нууц товчоон"-д бидний гол судлагдахуун болсон *belgürde-* гэдэг үг байхгүй. "Монголын нууц товчоон"-д *bel* гэдэг өгүүлбэрийн эхинд тохиолддог үг хэдийгээр анхаарал татахуйц үг боловч утгазүйн үүднээс *bel-* язгуураас өөр, тийм ч учираас судлагчид энэ үгийг англиар "*bel 'even, also' [a rare word]*" гэж орчуулдаг<sup>37</sup>. Энэ үг эл утгаараа "Эрдэнийн товч" (79.v.20) "Алтан товч" (3028-р мөр)-д бас гардаг. Хэрэвзээ холбоотой гэж үзвэл өөрөө энэ талаар бичиж болно шүү дээ.

**Ц. Ишдорж:** *Бэлбэсэн* гэж морин дээр, хөл нь цагаан ч юм уу, өөр өнгөтэйг хэлдэг биш байгаа?

**Ц. Шагдарсүрэн:** Нутаг нутагт өөр байж болох юм. "Монгол хэлний товч тайлбар толь"-д "*малын дан ганц зүс*" гэж тайлсан байдаг.

## ABSTRACT

### THE ORIGIN AND MEANING OF THE ROOT "Bel-" IN MONGOLIAN

There is a head word "*belgürte- = belgürt'e-*" in the *Dictionnaire Ordos* by A. Mostaert (Antoine Mostaert), well-known Mongolist scholar and it is said in the dictionary that an alternative phonetic form of this word is *belbert'e-*. However, A. Mostaert didn't put this word as a regular head word but put two points by this word and explained the meaning of the word (in the phrase or sentence), like *завгүй бай-* 'to be busy', *бэрхдэ-*, *үүлээрдэ-*<sup>38</sup> 'to be too difficult, to get into difficulties, to be dismayed, to be at a loss' when he put some sample sentences which include the word. So it is evident that the exact meaning of the word wasn't clear that time.

This word is found twice in almost all manuscripts of "*Erdeni-yin tobā*", the source material for history of the 17<sup>th</sup> century. The word is first found in the harmonious poetry about Burte Ujin and the poetry about Hero Cilugen for a second time in the source material. It is surprising that although Igor de Rachewitz, an Australian scholar who researched "*Erdeni-yin tobā*" the most thoroughly used the translation of the word in *Dictionnaire Ordos* when translating it into English, he put this word in the part

<sup>36</sup> Ц. Шагдарсүрэн, *Бөөгийн зохиол болон туулийн хэлний утга судлалын зарим асуудалд*, - Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), N. 10 (2000), Seoul, 2001, pp. 117-127.

<sup>37</sup> Igor de Rachewitz, *The Secret History of Mongols*, Vol. one, Leiden-Boston, 2004, p. 605.

<sup>38</sup> Antoine Mostaert, *Dictionnaire Ordos*, vol. I-III, - Monumenta Serica, Monograph Series 5, Peking 1941, 1942, 1944; 63.b, 64.a-64.b.

of problem words<sup>39</sup>. In some manuscripts of "Erdeni-yin tobā" this word is written as it is first time, but it is replaced by a different word *γutuju qoāur-* 'to be left dishonorably'<sup>40</sup>. So it is proved again that meaning of this word is unclear in the 17<sup>th</sup> century.

Exact meaning of the word **belgürde-** had been clear during the time when the poetry by Burte Ujin and by Hero Cilugen was written first and the poetry had been inherited in written and oral way. However the word lost the original meaning over the years and this word was written with extra explanation or replaced with similar word in the later materials such as "Erdeni-yin tobā" and *Dictionnaire Ordos*.

Therefore, I am to clarify the origin and exact meaning of this word **belgürde-** in my report in relation to linguistics and historical events and circumstances: **belgürde-** 'become alone'.

As a result of the research, this word **belgürde-** has the same origin as *бэлбэсэн* (Mo. *belbesün*), a Mongolian word which means *to be left alone* or *widow*, and *бэлчир* (Mo. *belčir*), a Mongolian word which means *junction, crossroads, confluence*; *бэлчирлэ-* (Mo. *belčirle-*) – 'to meet at one point'. This word from the root **bel** also the same meaning in the Altaic languages such as Uigur (: *бэлмур*), Tuva (: *бэлдур*) and Manchu.

There is another word **bülügde-** in the poetry a by Gilügen in "Erdeni-yin tobā" and in order to make this word understandable, it was replaced with the word *γutuju qoāur-* 'to be left dishonorably'<sup>41</sup> as **belgürde-** was replaced. It is written in the *Dictionnaire Ordos* that both words have the same meaning<sup>42</sup>.


Considering as basis of Mongolian linguistics and historical facts, these two words **belgürde-** and **bülügde-** have different origins and meanings. To be clear: **bülügde-** 'to group' has the same origin as a word *бөлөг* ~ (Mo **bölüg**)- 'group' in English which is popular among Altaic languages. In this case, the word **bülügde-**, in comparison with word **belgürde-** have more or less negative meaning.

<sup>39</sup> Igor de Rachewiltz, John R. Krueger, Ulaan, *Erdeni-yin tobā* (Precious summary)- A mongolian Chronicle of 1662, Urga Text, 1, Canberra, 1990, pp. 207-208.

<sup>40</sup> *Erdeni yin tobā*, -Monumenta Historica, Tom.1, Fasc.1, Koblol-dü beledkegsen Ts.Nasunbaljir, Ulaanbaatar, 1961, 128-p. 1an: *Qad-un ündüsün Erdeni-yin tobčiy-a*, "Eine Pekinger Palasthandschrift"- Herausgegeben von Erich Haenisch, - Asiatische Forschungen, Band 14, Wiesbaden, 1966, s 212. L.3.

<sup>41</sup> *Qad-un ündüsün Erdeni-yin tobčiy-a*, "Eine Pekinger Palasthandschrift"- Herausgegeben von Erich Haenisch, - Asiatische Forschungen, Band 14, Wiesbaden, 1966, s 211. L.4.

<sup>42</sup> Antoine Mostaert, *Dictionnaire Ordos*, vol. I-III, - Monumenta Serica, Monograph Series 5, Peking 1941, 1942, 1944; p.102.b.



"...Эрдэнийн товч"-ийн [Ts. Sh. Version] шинэ хувилбар

Qad-un ündüsün erdeni-yin tabǎ kemekü teüke orosibai (Ts. Sh. Version)  
25 r 01 → (Cf. 25 r 03)

Хүндүсүн

1. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн  
 2. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн  
 3. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн  
 4. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн  
 5. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн  
 6. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн  
 7. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн  
 8. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн  
 9. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн  
 10. Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн Хүндүсүн

"...Эрдэнийн товч"-ийн [Ts. Sh. Version] хувилбарын 25 г. хуудас (25 г. 03 -р мөрийг үзнэ үү)





ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ
ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ
ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ
ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ
ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ
ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ
ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ
ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ
ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ
ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ	ᠠᠨᠠᠨᠠ

"...Эрдэнийн товч"-ийн E. Haenisch-ийн хувилбарын III, 38.r хуудас (5-р мөрийг үзнэ үү)




мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү
мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү
мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү
мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү
мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү
мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү
мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү
мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү
мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү
мөмнү	м	мүмнү	мөмнү	мнү	мнү	мнү	мнү	мнү	мнү


"...Эрдэнийн товч"-ийн E. Haenisch-ийн хувилбарын IV, 11.r хуудас (4-р мөрийг үзнэ үү)

ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ
ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ
ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ
ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ
ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ
ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ
ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ
ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ
ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ
ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ	ᠠᠮᠤᠨᠤ

"...Эрдэнийн товч"-ийн E. Haenisch-ийн хувилбарын IV, 11.v хуудас (3-р мөрийг үзнэ үү)




46r




46v

"...Эрдэнийн товч"-ийн Хэнтийн хувилбарын 46.г, в хуудас  
(46. г. 7-р мөрийг үзнэ үү)




52r



52v

"...Эрдэнийн товч"-ийн Хэнтийн хувилбарын 52. г, в хуудас  
(52. v. 14, 26-р буюу сүүлчийн мөрийг үзнэ үү)



Ш. Чоймаа, *Qad-un ündüsün quriyangxui altan tobč*, - Monumenta Mongolica: Tomus II (Centre for Mongol Studies, NUM), Ulaanbaatar, 2002, 297-р тал, 32. а. 1 (буюу талын хуудасын эхний мөрийг үзмүү).

